



PEACE & PERFECT
AUDIT LLC

“ПИЙС ЭНД ПЕРФЕКТ АУДИТ” ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар
болсон санхүүгийн тайлангийн тухай

2025 он

“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК

2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	3
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ.....	4
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН.....	5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	7
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН.....	8
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН.....	9
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	10
ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	11
ТОДРУУЛГА 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО.....	11
ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНГЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛС.....	16
ТОДРУУЛГА 4. ЗЭЭЛ.....	16
ТОДРУУЛГА 5. БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.....	16
ТОДРУУЛГА 6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ.....	17
ТОДРУУЛГА 7. БИЕТ БУС ХӨРӨНГӨ.....	17
ТОДРУУЛГА 8. БУСАД САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ.....	18
ТОДРУУЛГА 9. ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР.....	18
ТОДРУУЛГА 10. БУСАД ЭХ ҮҮСВЭР.....	18
ТОДРУУЛГА 11. ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨГЛӨГ.....	18
ТОДРУУЛГА 12. ХҮҮГИЙН БУС ОРЛОГО.....	19
ТОДРУУЛГА 13. БУСАД ОРЛОГО, ОЛЗ.....	19
ТОДРУУЛГА 14. ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ.....	19
ТОДРУУЛГА 15. БУСАД ЗАРДАЛ ГАРЗ.....	20
ТОДРУУЛГА 16. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ.....	20
ТОДРУУЛГА 17. ЗОХИСТОЙ БАЙДЛЫН ХАРЬЦАА.....	21
ТОДРУУЛГА 18. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ.....	22
ТОДРУУЛГА 19. ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА.....	22
ТОДРУУЛГА 20. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР.....	22
ТОДРУУЛГА 21. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ.....	22
ТОДРУУЛГА 22. ТАЙЛАНГИЙН ХЭРЭГЛЭЭ.....	22

“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК

БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр	“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК
Хариуцлагын хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Байгууллагын эрх барих дээд байгууллага	Хувьцаа эзэмшигчид: <ul style="list-style-type: none"> - Б.Төрболд 59 хувь - Г.Болор-Эрдэнэ 14 хувь - Т.Банзрагч 10 хувь - Г.Солонго 10 хувь - Ч.Доржнамжил 5 хувь - Н.Гантулга 2 хувь эзэмшдэг байна.
Регистрийн дугаар	6052363
Үүсгэн байгуулагдсан огноо	2016.03.04
Үйл ажиллагааны чиглэл	Зээлийн үйл ажиллагаа, цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ, Итгэлцлийн үйлчилгээ, Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, Гадаад валютын арилжаа;
Тусгай зөвшөөрөл	2016 онд банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл
Удирдлага	Гүйцэтгэх захирал Б.Төрболд нь 2017 оны 3 дугаар сарын 10-ний өдөр томилогдсон.
Ажиллагсдын тоо	42
Харьяалах татвар, нийгмийн даатгалын хэлтэс	Нийслэлийн Санхүү, төрийн сан Нийслэлийн татварын хэлтэс Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, соёл амралтын хүрээлэн гудамж, Централ парк барилга, 7 давхар Утас: 88118445
Аудитор	Пийс энд Перфект аудит ХХК, Хараат бус баталгаажуулалт, санхүүгийн үйлчилгээний итгэмжлэгдсэн байгууллага Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, Ситиус, 6 давхар 604 тоот Утас: 80116813 E-mail: peaceandperfectaudit@gmail.com

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Төрболд болон ахлах нягтлан бодогч Б.Оюун-Эрдэнэ 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх байгууллагын санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ



Б.ТӨРБОЛД

Б.ОЮУН-ЭРДЭНЭ



PEACE & PERFECT
AUDIT LLC

“ПИИС ЭНД ПЕРФЕКТ АУДИТ” ХХК

2025 оны 2 дугаар сарын 19-ны өдөр

№.....
A25 / 010.
Улаанбаатар хот, Монгол улс

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК-ийн Удирдлага-д

Дүгнэлт

Бид “СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан. Бид Монгол Улсын “Аудитын тухай” хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хуулиар шаардсан шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид найдаж байна.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн яамнаас гаргасан холбогдох заавар, журмын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах нь байгууллагын удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, үүнтэй холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагууд орно.

Засаглах удирдлага нь байгууллагын санхүүгийн тайлагналын процесст хяналт тавих үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

Ул үндэслэлтэй баталгаа нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгуудын талаар аудитын нотлох зүйл олж авах түүврийн горимыг гүйцэтгэх ажил багтана.

Сонгон авах горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж болох эрсдэлийн үнэлгээг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна.

Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлыг харгалзаж үздэг ба энэ талаар дүгнэлт гаргах зорилгоор биш, зөвхөн тухайн нөхцөлд зохистой аудитын горимуудыг тодорхойлоход чиглэдэг. Мөн аудитын ажилд удирдлагын хийсэн томоохон тооцоолууд болон баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг үнэлэх ажлууд багтана.



“ПИЙС ЭНД ПЕРФЕКТ АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.НОМИНЧУЛУУН
Ч.НОМИНЧУЛУУН

Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, Ситиус төвийн 6-р давхарт
604 тоот, Улаанбаатар хот, Монгол Улс
Утас: 976- 80116813
И-мэйл: peaceandperfectaudit@gmail.com

“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

Төгрөгөөр

Үзүүлэлт	Тодруулга	2023.12.31	2024.12.31
Хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах зүйлс	3	3,466,647,497.17	7,619,507,449.15
Зээл /цэврээр/	4	3,120,644,359.34	8,271,197,277.31
Бусад санхүүгийн хөрөнгө	5	3,990,234,368.75	5,424,945,318.04
Татвар, НДШ-ийн авлага		-	4,915,337.33
Үндсэн хөрөнгө /цэврээр/	6	585,544,781.14	588,026,425.79
Биет бус хөрөнгө /цэврээр/	7	11,873,916.69	-
Бусад санхүүгийн бус хөрөнгө	8	-	154,329,397.93
Нийт хөрөнгө		11,174,944,923.09	22,062,921,205.55
Өр төлбөр ба эздийн өмч			
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр			
Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	9	2,018,856,512.00	4,627,295,292.70
Бусад эх үүсвэр	10	817,575,456.30	189,162,655.33
Бусад санхүүгийн өр төлбөр		2,906,086,530.52	2,000,000,000.00
Татвар, НДШ-ийн өр төлбөр	11	436,498,912.68	8,135,503,088.26
		313,674,152.46	254,995,089.42
Нийт өр төлбөр		6,492,691,563.96	15,206,956,125.71
Өөрийн хөрөнгө			
Хувь нийлүүлсэн хөрөнгө		2,500,000,000.00	3,500,000,000.00
Хуримтлагдсан ашиг, алдагдал		2,182,253,359.13	3,355,965,079.85
Өөрийн хөрөнгийн дүн		4,682,253,359.13	6,855,965,079.85
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		11,174,944,923.09	22,062,921,205.55

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

Төгрөгөөр

Үзүүлэлт	Тодруулга	2023.12.31	2024.12.31
Хүүгийн орлого		581,869,412.56	1,821,436,616.56
Банканд байршуулсан хөрөнгийн		-	5,855,713.60
Зээлийн		572,658,500.40	2,197,729,127.95
Бусад		9,210,912.16	-
(Хүүгийн орлогын буцаалт)		-	(382,148,224.99)
Хүүгийн зардал		90,210,330.23	1,019,219,926.97
Итгэлцлийн үр шим		-	630,881,653.09
Зээлийн		70,230,330.23	127,395,338.27
Үнэт цаасны		-	260,942,935.61
Бусад		19,980,000.00	-
Хүүгийн цэвэр орлого		491,659,082.33	802,216,689.59
Эрсдэлийн сангийн зардал		33,168,031.27	171,307,835.89
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого		458,491,051.06	630,908,853.70
Бусад орлого		7,737,057,609.62	9,214,764,179.28
Хүүгийн бус орлого	12	7,692,779,312.62	9,159,969,083.55
Бусад орлого, олз	13	44,278,297.00	54,795,095.73
Бусад зардал		5,773,910,966.25	6,208,215,565.52
Хүүгийн бус зардал	14	5,681,506,956.38	6,078,297,963.41
Бусад зардал, гарз	15	92,404,009.87	129,917,602.11
Татвар төлөхийн өмнөх ашиг		2,421,637,694.43	3,637,457,467.46
Орлогын татварын зардал		242,163,769.40	363,745,746.74
Цэвэр ашиг		2,179,473,925.03	3,273,711,720.72
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал		2,179,473,925.03	3,273,711,720.72
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн		2,179,473,925.03	3,273,711,720.72

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

Төгрөгөөр

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Дүн
2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	2,500,000,000.00	873,779,434.10	3,373,779,434.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
Залруулсан үлдэгдэл	2,500,000,000.00	873,779,434.10	3,373,779,434.10
Тайлант үеийн цэвэр ашиг	-	2,179,473,925.03	2,179,473,925.03
Ногдол ашиг	-	(871,000,000.00)	(871,000,000.00)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,500,000,000.00	2,182,253,359.13	4,682,253,359.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
Залруулсан үлдэгдэл	2,500,000,000.00	2,182,253,359.13	4,682,253,359.13
Тайлант үеийн цэвэр ашиг	-	3,273,711,720.72	3,273,711,720.72
Ногдол ашиг	-	(2,100,000,000.00)	(2,100,000,000.00)
Өмчид гарсан өөрчлөлт	1,000,000,000.00	-	1,000,000,000.00
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,500,000,000.00	3,355,965,079.85	6,855,965,079.85

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

Үзүүлэлт	Төгрөгөөр	
	2023.12.31	2024.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	5,794,381,558.64	12,723,398,865.69
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	591,080,324.72	4,655,703,162.35
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	2,018,856,512.00	3,483,440,834.48
Бусад	3,184,444,721.92	4,584,254,868.86
Мөнгөн зарлагын дүн (-)	4,368,029,835.02	8,662,570,459.77
Олгосон зээл	2,112,921,442.90	3,898,298,178.49
Буцаан олгосон итгэлцэл, үр шим	547,866,854.34	630,881,653.09
Ажиллагсдад олгосон	911,497,728.72	1,388,102,922.66
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	552,397,566.07	1,139,713,756.81
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	13,267,943.65	16,447,839.36
Бусад	230,078,299.34	1,589,126,109.36
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,426,351,723.62	4,060,828,405.92
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	1,000,056,125.00
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	-	56,125.00
Хүлээн авсан ногдол ашиг	-	1,000,000,000.00
Мөнгөн зарлагын дүн (-)	-	194,770,367.01
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	160,218,767.01
Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	34,551,600.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	805,285,757.99
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	44,278,297.00	2,600,000,000.00
Банк санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан	-	600,000,000.00
Бусад	44,278,297.00	2,000,000,000.00
Мөнгөн зарлагын дүн (-)	92,404,009.86	3,313,254,211.93
Банк санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн	-	1,213,254,211.93
Төлсөн ногдол ашиг	-	2,100,000,000.00
Бусад	92,404,009.86	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(48,125,712.86)	(713,254,211.93)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,378,226,010.76	4,152,859,951.98
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,088,421,486.41	3,466,647,497.17
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,466,647,497.17	7,619,507,449.15

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно